



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 07 сарын 01 өдөр

Дугаар A/456

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар захирамжаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Гучин-Ус суманд зохион байгуулагдах Уран бэр хүндэтгэлийн арга хэмжээний зардалд 2,000,000 (Хоёр сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх 2,000,000 (Хоёр сая) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100776

D:My Doc. Zahiramj. Zasag darga